

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 р сарын 10 ны өдөр

Мандалговь

Тус статистикийн хэлтэс нь МУ-ын Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон, ҮСХ-ны дарга, аймгийн статистикийн хэлтсийн дарга нарын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ, удирдлагуудаас өгсөн ажлын чиглэл, тогтоол шийдвэрүүдийг үндэслэн албан ёсны статистикийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, үнэн зөв, шуурхай бодит байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулах, судалгааны чанарыг дээшлүүлэх, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэн идэвхи санаачлага, бүтээлч ажиллагааг эрчимжүүлэх, аймгийн хөдөө аж ахуйн байдал, хүн амын чиглэлээр танилцуулга бэлдэх, хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн хөтлөлтийн сайжруулах, мэдээллийн цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, мэдээллийн технологи портал вэб сайтын баяжилтыг хангах, хэрэглэгчдэд үйлчлэх зорилтуудыг өмнөө тавьж амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.


I БҮЛЭГ: АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ

1.МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)

Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны А/03 тоот тушаалаар батлагдсан нийслэл, аймгийн статистикийн газар хэлтсээс ҮСХ-д 2014 онд ирүүлэх албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг мөрдөж, оны эхэнд ирсэн хүрээгээр аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулж, 60 гаруй мэдээ тайланг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан.

2014 онд ирүүлэх албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг Аймгийн Засаг даргын А/86 тоот захирамж гаргуулан бүх сумд, аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллаж байна.

Мэдээний хүрээнд зайлшгүй өөрчлөлт орох тохиолдолд холбогдох газар, хэлтсийн мэргэжилтэнтэй тохирч байгаа учир мэдээний хамралт 100 хувьтай байгаа юм. Тус аймаг энэ онд шинээр ажил үйлчилгээ явуулсан болон үйл



ажиллагаагаа өөрчлөн сэргээж, зээл тусламжинд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг дотоод мэдээллийн системд бүрэн хамруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Мэдээллийн хамралтыг нэмэгдүүлж аж үйлдвэрийн мэдээнд шинээр 3 аж ахуйн нэгж нэмж мэдээлсэн.

Нийт 62 нэрийн давхардсан тоогоор 1731 мэдээг 100 хувь хугацаанд нь бүрэн интернетээр дамжуулсан. Үүнд хөдөө аж ахуйн 390, аж үйлдвэрийн 117, тээврийн 9, зочид буудал, зоогийн газрын 87, худалдааны 344, үсчин гоо сайхны 4, төрийн бус байгууллагын 68, мал эмнэлгийн 84, сүм хийдийн 31, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний 59, мэргэжлийн түр

сургалтын 12, холбооны 12, орон сууц нийтийн аж ахуйн 1, бизнес регистрийн 108 аж ахуйн нэгжийн мэдээллийг тус тус тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээллээ. Харин сонгогдсон аж ахуйн нэгж тухайн сард үйлдвэрлэл явуулаагүй тохиолдолд мэдээ бүрийн тайлбарыг хамт явуулж байлаа.

Энэ онд мэдээний тасалдал, хожимдол гаргаагүй, мэдээний графикт өдрийн 17 цагт багтаан мэдээг хэлтсийн дарга, ахлах өөрийн биеэр нэг бүрчлэн шалгаж, мэдээ мэдээллийн чанарын асуудалд анхаарлаа хандуулан, хамралт бүрэн байгаа эсэхийг үзэж, холболтыг хийж дамжуулдаг.

2.МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)

Энэ оны байдлаар ҮСХ-д гаргаж өгвөл зохих мэдээг 100 хувь хугацаанд нь гаргаж, дамжуулбал зохих графикт өдөр нь бүрэн дамжуулсан. Энэ онд мэдээ дамжуулах, холболт хийхэд ямар нэг саатал гараагүй үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Сар бүрийн 4, 5, 21, 28-нд нийт сард 4 удаагийн мэдээг оройн 17 цагт багтаан дамжуулж байна. Мөн 7 хоног бүрийн 3 дахь өдөр үнийн мэдээг тогтмол дамжуулж хэвшсэн.

Мэдээнүүдийг програмын дагуу шивж, алдааг бүрэн засварлан үр дүнгийн хүснэгтийг үүсгэн өнгөрсөн мөн үе болон өмнөх сарын мэдээтэй уялдуулан шалгаж, тодруулах шаардлагатай мэдээг ААНэгжүүдээсээ тодруулан шалгадаг.

Цахим холболтоор дамжуулсан мэдээний бүртгэлийг мэргэжилтнүүд өөрсдөө тогтмол хөтлөхийн зэрэгцээ үндсэн бүртгэлийг ахлах мэргэжилтэн нэгтгэн хөтөлж заншсан.

3. МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (ШЗ)

Үндэсний Статистикийн Хороонд дамжуулах мэдээ тайланг салбар хариуцсан мэргэжилтнүүд сумд болон мэдээлэгчдээс шалган авч програмд боловсруулсны дараа хэлтсийн ахлах мэргэжилтэн хүлээн авч логик шалгалтуудыг хийж өнгөрсөн оны болон өмнөх сарын гүйцэтгэлүүдтэй зэрэгцүүлэн үзэж баталгаажуулан төвд мэдээлж байснаар мэдээ тайлангийн алдаагүй ажиллаж байна.

Хэлтсийн дарга мэдээний үнэн зөв байдалд байнгийн хяналт хийж 8 сумын багийн засаг дарга нарт анхан шатны мэдээний бүртгэлийг сайжруулах талаар зөвлөмж өгч ажилласан. Мөн жил, улирлын мэдээг аймгийн төрийн сангийн хэлтэс, татварын хэлтэст ирүүлсэн мэдээтэй нэг бүрчлэн шалгаж үнийн дүн их зөрүүтэй аж ахуй нэгжийн тайланг дотруулан тайлбар хүргүүлэн ажиллаж байна.

Шинээр орсон мэргэжилтнийг чадваржуулах зорилгоор, мэргэжилтнүүд мэдээг нь хамтран шивж, зааж сургах, алдааг шалгах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Мөн эрүүл мэндийн газрын улсын байцаагчтай хамтран эрүүл мэндийн төвийн эмнэлэгүүдээр явч бүртгэл мэдээлэлтэй танилцаж заавар зөвлөмжийг хүргүүллээ.

4. ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)

2014 онд Хүн ам өрхийн мэдээллийн сангийн програм өөрчлөгдөн онлайн болсонтой холбогдуулан бүх сумдын багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч нарын сургалтыг 15 сумаар явж зохион байгуулсан. Мөн 12 сарын 8 нд багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч нарын давтан сургалтын аймгийн төв Мандалговь хотноо зохион байгуулсан. Манай аймгийн хувьд ХАОВ-

аас ХАӨМС програмуу шилжих явцад 3400 гаруй регистрийн дугаарын давхардал гарсан бөгөөд энэхүү давхардлыг аймгийн хэмжээнд арилгах ажлыг хэлтсийн ажилтнууд, гэрээт ажилтны хамт хийж гүйцэтгэлээ. Мөн УБЕГ-мэдээллийн санд байгаа хэдийд ХАӨМСанд ороогүй байсан 2052 хүний харъяалагдах сум багт нь оруулж мэдээллийн санг цэгцлэн ажиллаж байна.

ХАӨМСанг сайжруулах ажлын хүрээнд Хяналтаар Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Гурван сайхан, Өндөршил, Өлзийт Говь-Угтаал, Дэрэн зэрэг 7 суманд томилолтоор ажиллаа.

5. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)

2014 оны эхний байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 698 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага байна. Үүнийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл үйл ажиллагаа явуулж байгаа 513, үйл ажиллагаа нь эхлээгүй 66, үйл ажиллагаагаа түр зогсоосон 96, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон 17, бусад шалтгаантай 6 байгууллага байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 73,5 хувь буюу 513 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаггүй, эзэн нь өөр аймаг хотод шилжсэн, бүртгэлээс хасах боломжтой нилээд аж ахуйн нэгжүүд байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа 513 байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзэхэд ХХК - 263, ХК - 3, ББН - 4, ЗБН - 1, хоршоо - 49, ТӨҮГ - 1, ОНӨҮГ-16, төсөвт байгууллага-130, ТББ-46 байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа 513 байгууллагыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 2013 онд төрийн 101, хувийн 362, орон нутгийн өмчийн 49, гадаад улсын 1, нийт 513 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг сумдаар нь авч үзвэл Сайнцагаан суманд 234 буюу 45,6 хувь, Эрдэнэдалай суманд 34 буюу 6,6 хувь нь ногдож байна. Цагаандэлгэр, Говь-Угтаал, Луус, Дэлгэрцогт суманд хамгийн бага буюу 12-16 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагыг ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл, 1-9 ажиллагчидтай аж

ажуын нэгж, байгууллага 388 буюу 75,6 хувь, 10-19 ажиллагчидтай аж ажуын нэгж, байгууллага 57 буюу 11,1 хувь, 20-49 ажиллагчидтай аж ажуын нэгж, байгууллага 52 буюу 10,1 хувь, 50-иас дээш ажиллагчидтай аж ажуын нэгж, байгууллага 16 буюу 3.1 хувийг бүрдүүлж байна.

Энэ онд жилийн эцсийн болон эхний гурван улиралд сонгогдон ирсэн 108 аж ажуын нэгжээс БР-1, 2 маягтаар аж ажуын үйл ажиллагааны тухай мэдээллийг тодруулан авч шивж дамжууллаа.

Бизнес регистрийн программ шинэчлэгдсэнтэй холбогдуулан бизнес регистрийн программ ашиглалтын талаар онлайн сургалтанд оролцов.

ҮСХорооноос 2014 оны жилийн эцсийн мэдээний хүрээгээр салбар тус бүрээр тодруулахаар ирсэн аж ажуын нэгж, байгууллагуудын мэдээллийг 15 сум, аж ажуын нэгж байгууллагын дарга, захирал нартай ярьж тодруулан хугацаанд нь явуулж байв.

Бизнес регистрийн мэдээллийн санд энэ 12 сарын байдлаар 781 аж ажуын нэгж бүртгэлтэй байгаагаас үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа 531, үйл ажиллагаагаа эхлээгүй 69, үйл ажиллагаа нь түр зогссон 142, бүрэн зогссон 22, татан буугдсан 14, бусад шалтгаантай 3 аж ажуын нэгж, байгууллага байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ажуын нэгжийн 68,0 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Харин 30,2 хувь нь ямар нэгэн шалтгаантай үйл ажиллагаа явуулаагүй байна.

II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

6. МАЛ ТООЛЛОГО (Ш6)

Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Малын индексжүүлсэн даатгал” (МИД) төслийн хүрээнд зохион байгуулж буй хагас жилийн мал тооллогыг 2014 оны 6 сарын 5-оос 6 сарын 12-ны хооронд бүх сумдад амжилттай зохион байгуулав.



2014 оны хагас жилийн мал тооллогоор аймгийн хэмжээнд нийт 2375 өрх сонгогдож түүвэр судалгаанд бүх өрх хамрагдсан. Хагас жилийн мал тооллогыг МИД програмд шивж хугацаанд нь дамжуулав. Тооллогын хяналтыг аймгийн МИД төслийн ажилчидтай Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Адаацаг, Өлзийт, Хулд,

Луус сумдад хийлээ. Хяналтаар ямар нэгэн зөрчил илэрсэнгүй. Тооллогын зардлыг хувиарын дагуу сумдад хувиарлан баримтыг бүрдүүлэн авлаа.

2014 оны мал тооллогын сургалтыг 2014.11.07-оос 8-ны өдрүүдэд сумдын төрийн сангийн төлөөлөгч, багийн засаг дарга нарт мал тооллогын маягт, програмын заавар, мал тооллогын онцлог, анхаарах асуудлууд сэдвээр сургалтыг зохион байгууллаа.

“Мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай” аймгийн Засаг даргын 2014 оны 12 сарын 05-ны өдрийн А/734 захирамж гаргуулан аймгийн засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Уг захирамжийн дагуу Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдад хяналтын тоогоор ажиллаж нийт 100 өрхөөр орж малын тоог тулган шалгахад ямар нэг зөрчил дутагдал илэрсэнгүй Мөн сумдын засаг дарга нарт аймгийн Засаг даргын орлогчийн 2014 оны 12 сарын 1-ний өдрийн 1/1592 тоот, Статистикийн хэлтсийн даргын 2014 оны 12 сарын 5-ны өдрийн 63 тоотоор мал тооллогын тухай дэлгэрэнгүй зөвлөмж хүргүүлсэн.

2014 оны Мал, тэжээвэр амьтдын тооллогыг сумдад 12 сарын 7-аас 17-ийг хүртэл хугацаанд амжилттай зохион байгуулж багийн засаг дарга өөрсдийн малчин өрхийн мэдээллийг програмд шивж оруулаад байна.



7. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Ш7)

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны судлаач нартай хэлтсийн даргын зүгээс шинээр гэрээ байгуулан, гэрээний дагуу үр дүнг тооцож ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг 304 өрх сонгогдож нөөц гурван өрх авсан байна. Сар бүр ахлагч судлаачын дамжуулсан өрхийг шалгаж алдааг уншуулан үндэсний статистикийн хороонд дамжуулж хэвшээд байна. Судалгааны хүрээг багийн засаг даргаар тухай бүр нь шинэчлэн Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байна. Ардчилсан засаглал судалгааг 5 сумын 52 өрхөөс судлаачаар дамжуулан аргачлал зааврын дагуу явуулж, Үндэсний статистикийн хороонд графикт хугацаанд нь мэдээлж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгаанд 24078,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүний 4009,1 мянган төгрөгийг өрх ба хөтөчийн урамшуулалд, 10258,5 мянган төгрөгийг ахлагч, судлаач, шивэгч нарын ажлын хөлсөнд, 9810,4 мянган төгрөгийг тээвэр, холбоо болон шатахууны зардалд олгож, явц байдлыг сар тутам хяналтандаа байлгаж ажиллав. Оны эхэнд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг сумдад шалгах удирдамж, хяналт шалгалтын графикийг гарган энэ дагуу судалгааны ахлагч аймгийн төвд сар бүр 2-5 өрх, Өлзийт Өндөршил суманд эхний 5 сард сонгогдсон өрхүүдээс сум бүрийн 8 өрхөөр явж хяналт хийж, судлаач нарт хяналтаар гарсан зөрчил, дутагдалын талаар танилцуулан, зөвлөмж өгч ажиллалаа.

8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (Ш8)

Эхний хагас жилийн байдлаар ажиллах хүчний судалгааг 240 өрх сонгогдож нөөцөөс нэг өрх авсан байна. Судалгааг Үндэсний статистикийн хороонд явуулах графикт хугацаанд нь дамжуулж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Мөн Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Хулд, Эрдэнэдалай сумдад хяналт хийж судлаач нарт заавар зөвлөмж өгч ажиллаа.

III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРГАЛТ,

10. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)

Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу хэлтсийн ажилтнууд ажлын байрны сургалтыг 14 хоног дутам зохион байгуулж өөрсдийн мэдлэг чадварыг тогтмол сайжруулан ажиллаж байна.

А) Дундговь аймгийн Статистикийн хэлтэс нь 2014 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу анхан шатны Статистик мэдээ хариуцсан ажилтнууд буюу багийн засаг дарга нар, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт зориулсан сургалтыг 2014 оны 11 сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтыг аймгийн Засаг дарга С.Од-Эрдэнэ болон хэлтсийн дарга Н.Түвшинжаргал нар нээж, Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Уянга, мэргэжилтэн С.Доржханд нар хичээл заалаа.

Уг сургалтанд:

1. “Статистикийн салбарынэрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг”
2. “Хүн ам нийгмийн статистик мэдээ гаргах аргачлал, заавар”
3. “Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэр нөхөх заавар”
4. “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн агуулга, заавар”
5. “Монгол Улсын Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баг, сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудын үүрэг оролцоо”
6. “Хөдөө аж ахуйн салбарын мэдээ тайлан гаргах заавар, аргачлал”
7. “2014 оны жилийн эцсийн мал тооллого, анхаарах асуудлууд”
8. Цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл сэдвүүдээр бүтэн өдрийн сургалт хийлээ.

Сургалтанд 14 төрийн сангийн төлөөлөгч оролцож 100 хувь (1 сум буюу Цагаандэлгэр сум Төрийн сангийн төлөөлөгчгүй байгаа), 65 багийн дарга буюу 98.5 хувь нийт 79 хүн оролцож 98.8 хувийн ирцтэй оролцлоо.



Сумдын төрийн сангийн төлөөлөгч, багийн засаг дарга нарын 2014 оны 11 сарын 7-ны өдрийн сургалтын ирц

АД	СД	Сум/дүүрэг	БД	Баг/хороо	Овог,нэр	Утас	Гарын үсэг
Адаацаг							
48	04	Адаацаг сум	51	1-р баг, Тавин	Т. Уралын	94448081	948226707
48	04	Адаацаг сум	53	2-р баг, Ар-Урт	У. Уралын		У. Уралын
48	04	Адаацаг сум	55	3-р баг, Өвөр-Урт	М. Сүрэншарва	95257655	М. Сүрэншарва
48	04	Адаацаг сум	57	4-р баг, Сүм	Б. Сүрэншарва	99332106	Б. Сүрэншарва
48	04	Адаацаг сум	59	5-р баг, Хашаат	Б. Сүрэншарва	95787095	Б. Сүрэншарва
Баянжаргалан							
48	07	Баянжаргалан сум	51	1-р баг, Шилийн гол	В. Даш	88469598	В. Даш
48	07	Баянжаргалан сум	53	2-р баг, Энгэр-Ус	Б. Даш		Б. Даш
48	07	Баянжаргалан сум	55	3-р баг, Аргатай	Э. Даш	88017181	Э. Даш
Говь-Угтаал							
48	10	Говь-Угтаал сум	51	1-р баг, Ажирхай	С. Сүрэншарва	98906977	С. Сүрэншарва
48	10	Говь-Угтаал сум	53	2-р баг, Морьт	О. Сүрэншарва	98211952	О. Сүрэншарва
48	10	Говь-Угтаал сум	55	3-р баг, Хонгор	Б. Сүрэншарва	92052997	Б. Сүрэншарва
Гурвансайхан							
48	13	Гурвансайхан сум	51	1-р баг, Элгэн	О. Сүрэншарва	95495599	О. Сүрэншарва
48	13	Гурвансайхан сум	53	2-р баг, Дэрсэнэ ус	Н. Дэлгэр	86955800	Н. Дэлгэр
48	13	Гурвансайхан сум	55	3-р баг, Чулуут	Д. Сүрэншарва	91241694	Д. Сүрэншарва
48	13	Гурвансайхан сум	57	4-р баг, Гурвансайхан	В. Сүрэншарва	96690423	В. Сүрэншарва
48	13	Гурвансайхан сум	57	4-р баг, Гурвансайхан	У. Сүрэншарва		У. Сүрэншарва
48	13	Гурвансайхан сум	59	5-р баг, Суугаант	Ц. Энхтөвшин	99839192	Ц. Энхтөвшин
Дэлгэрхангай							
48	16	Дэлгэрхангай сум	51	1-р баг, Толь			
48	16	Дэлгэрхангай сум	53	2-р баг, Таргат	Б. Дэлгэр	99285920	Б. Дэлгэр
48	16	Дэлгэрхангай сум	55	3-р баг, Ар шалагтай	М. Дэлгэр	95835025	М. Дэлгэр
48	16	Дэлгэрхангай сум	57	4-р баг, Номгон	У. Дэлгэр	95235089	У. Дэлгэр
Дэлгэрцогт							
48	19	Дэлгэрцогт сум	51	1-р баг, Баянбулаг	М. Сүрэншарва	91852378	М. Сүрэншарва
48	19	Дэлгэрцогт сум	53	2-р баг, Шажуурт	С. Сүрэншарва	91199936	С. Сүрэншарва
48	19	Дэлгэрцогт сум	55	3-р баг, Дэлгэр-Эмт	В. Сүрэншарва	98622144	В. Сүрэншарва
Дэрэн							
48	22	Дэрэн сум	51	1-р баг, Алаг-Өндөр	М. Сүрэншарва	99877729	М. Сүрэншарва
48	22	Дэрэн сум	53	2-р баг, Сэрүүл	С. Сүрэншарва	96015217	С. Сүрэншарва
48	22	Дэрэн сум	55	3-р баг, Долоод	У. Сүрэншарва	88758290	У. Сүрэншарва
48	22	Дэрэн сум	57	4-р баг, Бумбат	У. Сүрэншарва		У. Сүрэншарва
Өлзийт							
48	28	Өлзийт сум	51	1-р баг, Буянт-1	Б. Дэлгэр	88705502	Б. Дэлгэр
48	28	Өлзийт сум	53	2-р баг, Буянт-2	М. Дэлгэр	88596575	М. Дэлгэр
48	28	Өлзийт сум	55	3-р баг, Тагт	У. Дэлгэр	88706878	У. Дэлгэр
48	28	Өлзийт сум	57	4-р баг, Дэрт-1	У. Дэлгэр	88009398	У. Дэлгэр
48	28	Өлзийт сум	59	5-р баг, Дэрт-2	О. Дэлгэр	88602160	О. Дэлгэр
48	28	Өлзийт сум	61	6-р баг, Рашаант	Ө. Буял-Очир	88784520	Ө. Буял-Очир

В) 1.Статистикийн үүсэл хөгжил, тоон үзүүлэлт, статистикийн байгууллагын тогтолцоо, дундговь тооны хэлээр зэрэг сэдвүүдээр бэлтгэсэн сургалтыг мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн тогоочийн 2-р курсийн 348 –р

бүлгийн оюутнуудад 2014 оны 10 дугаар сарын 22 ны өдөр зохион байгуулж хичээлийг хэлтсийн мэргэжилтэн С.Доржханд, Б.Зүмбэрэл нар заалаа.

2. 2014 оны 11 сарын 11 ны өдрийн 11 цагт Дундговь аймгийн Сайнцагаан сумын “ГОВИЙН ИРЭЭДҮҮ ЦОГЦОЛБОР” сургуулийн 126 ангийн сурагч нарт “СТАТИСТИК ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ” сургалтыг хэлтсийн Дарга Н.Түвшинжаргал явууллаа.



3. Аж ахуйн нэгжийн нягтлан бодогч нарт 2 удаагийн сургалтын зохион байгуулж статистикийн хэлтсийн бүтэц зохион байгуулалт, ажилчдын танилцуулга, Статистикийн тухай хууль, мэдээний график, мэдээ, тайлан гаргахад анхаарах асуудлууд, нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийг сайжруулах талаар, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, жилийн эцсийн мэдээний маягтын заавар, Дундговь аймгийн сонирнолтой статистик, хэлтсийн дотоод мэдээлэл зэргийг багтаан нийт 60 ААН-ийн 32 нягтлан бодогч нарт сургалт хийлээ.



4.Бусад сургалт

- Сумдын орлогч нарт Мерси Кор олон улсын дундговь салбарын хүсэлтээр сумдад Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох талаар онлайн сургалтыг зохион байгуулсан.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг хэлтсийн бүх ажилтнуудын дунд зохион байгуулж бичиг хэргийг стандартын дагуу болгох талаар заавар зөвлөмж авч ажиллаж байна.
- Ургийн бичиг хөтлөх, түүний ач холбогдол сэдэвтэй сургалтыг аймгийн Аудитын газартай хамтран өндөр настан Аюур гуайгаас авч ургийн бичиг хөтөлж эхлээд байна.
- Т.Бямбасүрэн, Б.Зүмбэрэл нарыг чадваржуулах зорилгоор аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албанд анх орсон мэргэжилтнүүдийн чадваржуулах сургалтанд хамрууллаа.




Сар бүр хэвлэлийн бага хурлын презентацийг бэлтгэн хэлтсийн вэб хуудас, орон нутгийн МАРГАД телевиз, Хэлтсийн фэйсфүүк хуудсанд тогтмол байршуулж 12 удаа мэдээллэж ажилласан.



В) Хэлтсийн сар бүрийн танилцуулга, заавал хийх 4 танилцуулга тус бүр дээр www.1212.mn EzStat, MonStat аппликейшнг байршуулан тогтмол мэдээлж байна.

Статистик мэдээллийг хаанаас авах вэ? мэдээллийн самбарыг хэлтсийн үүдэнд байрлуулан тогтмол мэдээллэж байна.

Аймгийн төв зам дагуу байрлах гэрлийн 8 шонд 16 ширхэг хулдаасан самбарыг байршуулаад байна. Энэ хулдаасан самбарт “Мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn”, “Статистик хөгжилд хөтлөгч хүч” тус бүр 8 ширхэгийг байршуулсан юм. Мөн аймгийн 7 хоног дутмын Дундговийн амьдрал сонинд 7 хоногийн үнэ болон “Статистик мэдээллийг хаанаас авах вэ?” буланг хэвлүүлсэн.



Г) 2013 оны жилийн эцсийн мэдээний танилцуулгыг боловсронгуй болгон гаргаж 80 ширхэг хэвлэн тараасны зэрэгцээ сүлжээгээр өгөх, фэйсфүүк Вэб хуудсанд тавих зэргээр тархаах ажлыг хийж байна. Мөн “Дундговийн амьдрал” сонинд улирлын мэдээний бичмэл танилцуулгыг тогтмол хэвлүүлэв.

https://www.facebook.com/photo.php?fbid=748393435197569&set=pcb.555579061239826&type=1&theater

Most Visited Problem loading page Facebook 0 Requests Facebook

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдал (2014 оны эхний 10 сарын байдлаар)

I.Төсвийн орлого

Санхүү, төдий сангийн хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.8 хувиар өсч 3450.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зөвхөн орлогын төлөвлөгөө 21.4 хувиар давж биелэн 1377.4 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дунгаар 4828.3 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дунгаар орлогын төлөвлөгөөний биелэлт 114.3 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 33570.8 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 97.8 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсөөс авсан санхүүгийн дэмжлэг 7000.5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 6500.6 тусгай зориулалтын шилжүүлгээс 16618.7 нийт 301119.9 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Өлзийт, Говь-Угтаал, Сайхан-Овоо сумд 3133.9-129055.5 мянган төгрөгөөр таслан бол бусад сумд төлөвлөгөөгөө 1,6-143.6 хувиар давуулан биелүүлжээ.

II.Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага оны эхний 10 сарын байдлаар 29800.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 27.3 хувиар өсчээ. Зарлагын төрлөөр авч үзэл цалин хөлсний зардал өмнөх оноос 10.4 хувиар өсч 13382.0 сая төгрөг, нийгмийн халамийн үйлчилгээ 2597.6 сая болж өмнөх оноос 15.4 хувиар буурчээ.

III.Банк

Банжны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар өсч 70261.9 сая төгрөг болов. Үүнээс хугацаа

хэтэрсэн зээл 224.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3 дахин өсчээ. Чанаргүй зээл 130.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдлийн 0.5 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оноос 13.0 хувиар өсч 23727.3 сая төгрөг болов.

IV.Бүртгэлтэй ажилгүй иргэн

2014 оны 10 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 612 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 65 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 59.5 хувь буюу 364 хүн нь эмэгтэйнчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 206 ажилгүйчүүд ногдож байхад Өндөрцэн /594/, Банжаргалан /573/, Дэрэн /301/, Сайхан-Овоо /281/ байгаа нь аймгийн дундаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.3 хувь нь магистр, доктор, 12.9 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 3.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 5.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 35.5 хувь нь бүрэн дунд, 25.8 хувь нь суурь, 12.6 хувь нь бага, 3.4 хувь нь боловсролгүй иргэд байна.

V. Ажлын байрны зуучлал

Хөдөлмөрийн хэлтсийн 2014 оны эхний 10 сарын мэдээгээр 657 хүн ажлын байранд зуучлагдан орсон байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарар авч үзэхэд 35.2 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 32.9 хувь нь ХАА ан агнуур ойн аж ахуй, 6.7 хувь нь зочид буудал, зоогийн газар, 5.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 4.4 хувь нь боловсрол, 14.9 хувь нь бусад салбарт ногдож байна.

VI. Нийгмийн даатгал

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны эхний 10 сард 17354.1 сая төгрөг, зарлага 17342.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 2466.8 сая төгрөг буюу 16.6 хувь, зарлага 3387.5 сая төгрөг буюу 24.3 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд эхний 10 сард 10078 хүн шимтгэл төлөж,

Nansalmaa Tuvshinjargal Дундговь
аймгийн статистикийн хэлтэс
November 12

Add a description

Tag Photo Add Location Edit

Like Comment Stop Notifications Share

Write a comment...

Complete your profile Edit Profile

Nansalmaa, which city do you live in? 60%

- Ulaanbaatar, Mongolia
- Dund-Gobi, Dundgovi, Mongolia
42 friends live here
- Los Angeles, California
1 friend lives here

Enter current city

Confirm

Хэлтсийн мэдээллийн самбарыг шинэчлэн 2013 оны жилийн эцсийн мэдээ тайланг график байдлаар харуулан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн явуулын 2 хөлтэй самбар хийж иргэдэд хаанаас мэдээлэл авч болох талаар мэдээлэл өгч байна.

Монгол улсад Статистикийн алба үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг Дундговь аймгийн хэмжээнд 2014.11.07-оос 11.08-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн ажлын хүрээнд аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Бидний амьдрал Статистикийн толинд” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж мөн багийн засаг дарга нар, төрийн сангийн төлөөлөгчдийн дунд асуулт хариултын “АХА”, “Гар бөмбөг”-ийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Асуулт хариултын АХА тэмцээнд Адаацаг сумын багийн засаг дарга Г.Уранбилэг түрүүлж, Өлзийт сумын Төрийн сангийн төлөөлөгч Б.Болдбаатар дэд байр, Гурвансайхан сумын багийн засаг дарга Ц.Энхтайван гуравдугаар байр эзэллээ.



Гар бөмбөгийн тэмцээнд Эрдэнэдалай, Луус сумын хамтарсан баг Тэргүүн байр эзэлж, Адаацаг, Сайхан-Овоо, Өндөршил сумдын хамтарсан баг хоёрдугаар байр, Дэлгэрхангай, Дэрэн сумдын хамтарсан баг гуравдугаар харин аймгийн Статистикийн хэлтсийн баг тусгай байрыг тус тус эзэллээ.



Аймгийн удирдлагууд, үе үеийн ахмад статистикчид, багийн засаг дарга нар, төрийн сангийн төлөөлөгчид хэлтсийн мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон хүндэтгэлийн хүлээн авалт боллоо.



Ойн арга хэмжээний үеэр багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч, статистикийн хэлтсийнхэнд шагналын хур буулаа.



Дундговь аймгийн Статистикийн хэлтэс, Дэлхийн зөн ОНХХ дундговь салбартай хамтран статистик мэдээ, мэдээллийн самбарыг хийж 15 суманд хүлээлгэн өглөө. Аймгийн төв Мандалговь хотноо 26-аас 28-ны өдрүүдэд зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон 200 гаруй хүмүүст сонирхуулан мэдээлэл өглөө.

Уг самбарт сумдын хүн ам, жилийн эцсийн мал тооллогын дүн багаар, төсвийн орлого, зарлага, банк санхүү, эрүүл мэнд зэрэг аймаг, сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг сум тус бүрээр нь хүснэгт болон графикаар харуулан байршууллаа.

12. ВЭБ БАЯЖИЛТ (Ш12)

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Стандартчилын үндэсний зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага”-ын дагуу байгууллагын нэр, лого, эрхэм зорилго,



ДУНДГОВЬ

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Танилцуулга | Статистикийн хууль | Тооллого | Шено мэдээ, мэдээлэл | Бюджет, төс | Нийгэм, эдийн засаг | Ил тод байдал

Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга

Нийгэмлэг: 2014 оны 06 сар 19, 14 цаг 45 минут



1. Ажил эрхлэлт, Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал Дундговь аймаг 2013 оны жилийн эцсийн байдлаар 44400 хүн амтай болж өмнөх оноос 0.45 хувь буюу 201 хүнээр буурсан байна. Нийт хүн амын 22135 нь буюу 49.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 67.0 хувь буюу 29733 хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь өмнөх оноос 63 хүнээр буурсан байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 48.6 хувийг эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлж байгаа нь өмнөх оноос 3.2 пунктээр буурсан байна. Нийт хүн амын 45.0 хувийг ажиллагсад эзэлж байгаа нь өнгөрсөн онд нийт шилжин явагсадын дунд эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагсад их байгаа нь харагдаж байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагсад зэрэг үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан ба эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо өсчээ. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 9.2 мянгад хүрч өмнөх оноос 23.4 хувиар өсчээ. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 93.5 хувийг ажиллагсад эзэлж байна.

ХҮНСНИЙ ГӨЛ НЭЭРИЙН БАГААНЫ ҮНЭ				
Баруун нэр, төрөл	И/2	И/23	И/30	И/07
Гурил, 1 зэрэг, кг	850	950	950	950
Хонины мах, кг	6500	8000	8000	8000
Ухрийн мах, кг	0	0	0	0
Ямааны эстай мах	6000	7000	7000	7000
Элсэн нөхөр, кг	1500	1600	1600	1600
Цагаан будаа, кг	2000	2100	2200	2200
Шингэн сүү, л	2200	1600	1600	1600
Ноолуурын үнэ 1кг-	55000	72000	75000	75000
Бөхний, А-80, 1 литр	1560	1570	1570	1570
Бөхний, А-82, 1 литр	1810	1810	1810	1810
Диелийн түлш, 1 литр	1890	1890	1890	1890

байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилго, бүтэц зохион байгуулалт, байгууллагын үйл ажиллагаан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, тухайн жилийн төсвийн төлөвлөгөө , сарын мэдээ, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, шинэ мэдээ, мэдээлэл, хаяг байршил, статистик мэдээ, холбогдох холбоос, зургийн цомог зэргийг байршуулан ажиллаж байна. Үүний үр дүнд вэб хандалт сүүлийн үед маш ихээр нэмэгдэж 7 хоногт 200-300 хүн тогтмол үзэж одоогоор [57729](#) хүн хандаад байна

Мөн аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг сар бүр тогтмол оруулдаг, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв, байдлын танилцуулга, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга, аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга зэргийг байршуулаад байна.



Шинэ мэдээ, мэдээлэл - Сарын бүрийн мэдээллээр хийсэн хэвлэлийн бага хурлын илтгэлийн файлыг сар бүрийн 15-ны дотор вэб хуудсанд тогтмол байршуулаад байна. Мөн аймгийн хүн ам, малын тоо, тариалсан талбай, хураасан ургац зэрэг үзүүлэлтийг сум бүрээр, 2000 оноос хойших онуудаар динамик бүрдүүлж оруулаад байна.

13. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ (Ш13)

Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг сар бүрийн 10 нд аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Хэлтсийн дарга нар 12 хувь хэвлэн тархаадаг бусад агентлагын дарга болон аж ахуй нэгж иргэдэд мэйл хаягаар өгч байна.



Тус хэлтсээс сар, улирал жилийн эцэст гарч буй албан ёсны статистик мэдээний танилцуулга, судалгаануудыг ном хэлбэрээр хэвлэн гаргаж, сар бүрийн 10 ны дотор аймгийн төр захиргааны удирдлагууд болон хэрэглэгчдэд мэдээлж байна. Сар улирлын мэдээний танилцуулгын хүснэгт маягыг байнга боловсронгуй болгож, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаан талаар улирал бүрийн танилцуулгад оруулан мэдээлж байна.

**Аймгийн эдийн засаг, нийгмийн байдал
(2014 оны эхний 4 сарын байдлаар)**

I. Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 94.3 хувьтай буюу 999.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 143.0 хувиар давж биелэл 525.7 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулав байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 1624.8 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 118.3 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 14886.9 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 88.1 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 3140.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 1214.6, тусгай зориулалтын шилжүүлгээс 7162.2, нийт 13887.7 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогоныхоо төлөвлөгөөг Өлзийт, Луус сумд 6058.4-15912.1 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө тасласан бол бусад сумд төлөвлөгөөгөө давуулан биелүүлжээ.

Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага оны эхний 4 сарын байдлаар 10105.7 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 23.0 хувиар өсчээ. Зарлагын төрлөөр авч үзвэл цалин хөлсний зардал өмнөх оноос 6.2 хувиар өсч 5231.6 сая төгрөг, нийгмийн халамжийн үйлчилгээ 902.0 сая болж өмнөх оноос 24.4 хувиар буурчээ.

II. Банк

Банкны эзэлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 45.9 хувиар өсч 57122.5 сая төгрөг болов. Үүнээс хугацаа хэтэрсэн эзэл 226.4

сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6 дахин өсчээ. Чанаргүй эзэл 87.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт эзэлийн үлдэгдлийн 0.55 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй эзэл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгалмаж өмнөх оноос 25.5 хувиар өсч 26846.8 сая төгрөг болов.



III. Бүртгэлтэй ажилгүй иргэн

2014 оны 04 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 544 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 34 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 55.5 хувь буюу 302 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 183 ажилгүйчүүд ногдож байхад Баянжаргалан /679/, Өндөршил /482/, Луус /286/, Говь-Угтаал /272/ байгаа нь аймгийн дундаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.2 хувь нь магистр, доктор, 9.7 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 5.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 5.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 42.1 хувь нь бүрэн дунд, 22.1 хувь нь суурь, 11.4 хувь нь бага, 2.9 хувь нь боловсролгүй иргэд байна.

IV. Ажлын байрны зуучлал

Хөдөлмөрийн хэлтсийн 2014 оны эхний 04 сарын мэдээгээр 186 хүн ажлын байранд зуучлагдан орсон байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 30.1 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 18.8 хувь нь эрчимд буудал, зоогийн газар, 14.5 хувь нь ХАА ан агнуур ойн аж ахуй, 10.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 10.2 хувь нь боловсрол, 15.8 хувь нь бусад салбарт ногдож байна.

V. Нийгмийн даатгал, халамж

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны эхний 4 сард 8602.9 сая төгрөг, зарлага 6331.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 935.9 сая төгрөг буюу 16.5 хувь, зарлага 976.7 сая төгрөг буюу 18.2 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд эхний 4 сард 7847 хүн шимтгэл төлөгч,



Nansalma Tuvshinjargal · Дундговь аймгийн статистик хэлтэс

May 19 48

Add a description

Tag Photo Add Location Edit

Unlike Comment Stop Notifications Share

You, Tserendulam Purebsuren, Ц. Мөнхдалгар, Byambaa Byambasuren and 2 others like this.


Write a comment.

Write a comment.

Sponsored Create Ad

Kempinski Hotel Khan...

Plan the perfect Wedding celebration with our comprehensive & efficient packages, customi...



Like Page

EduTech

Манайлагчид манайг сонгодог. Дэлхийн аваргын тоглолтыг WIFI EZCAST-ийн тусламжтайгаар...



Like Page

Жил бүр заавал хийх Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв, байдал танилцуулга, Ажил эрхлэлтийн байдал танилцуулга, Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга зэргийг Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга түүний орлогч, Засаг даргын

тамгын газрын дарга, тамгын газрын харьяа хэлтэс, агентлагын дарга нарт хэвлэн тархааж байна. Мөн хэлтсийн вэб сайтад байршуулан иргэдэд үйлчилж байна.

Дундговь аймгийн хүн ам, өрхийн үзүүлэлтийн төлөв байдлын тухай танилцуулга тараасан жагсаалт

Албан тушаал	Нэр	Хүлээн авсан хүний гарын үсэг
ИТХТ-ын дарга	С.Буджав	
Засаг дарга	С.Сүхбаатар	
Орлогч дарга	О.Бат-Эрдэнэ	
Тамгын газрын дарга	О.Чулуунбат	
ХБХ-ийн дарга	А.Өлзийбалжир	
НХХ-ийн дарга - 2	Д.Дулмаа	
СТСХ-ийн дарга	А.Ганбат	
ТЗУХ-ийн дарга	С.Хатанбаатар	
Хууль зүйн хэлтэс	Б.Түвшинбаяр	
БСГ-ийн дарга	Ц.Бумангарал	
НХУХ-ийн дарга	Ц.Ганбаяр	
Статистикийн хэлтэс	Н.Түвшинжаргал	
Хөдөлмөрийн хэлтэс	Ц.Батбилэг	
Цэргийн хэлтэс	Б.Амаржаргал	

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2013 ОНЫ ХҮН АМ, ӨРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээлүүдийг MOHSTAT, ezStat аппликэйшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google Play-с...

Нийгмийн үзүүлэлтийн 2013 оны түүвэр судалгааны нэгдсэн үр дүнгийн ном
тархаасан жагсаалт

Сумын нэр	Төрийн сангийн төлөөлөгчийн нэр	Гарын үсэг
Сайнцагаан	Бархасмаа	<i>Бархасмаа</i>
Адаацаг	Баяржаргал	<i>Моран</i>
Баянжаргалан	Дуламханд	<i>Д.Д</i>
Говь-Угтаал	Уранбилэг	<i>Уранбилэг</i>
Гурвансайхан	Дагмид	<i>Дагмид</i>
Дэлгэрхангай	Батхуяг	<i>Батхуяг</i>
Дэлгэрцогт	Эрдэнэцэцэг	<i>Эрдэнэцэцэг</i>
Дэрэн	Цогтбаатар	<i>Цогтбаатар</i>
Луус	Ундрахбаяр	<i>Ундрахбаяр</i>
Өлзийт	Болдбаатар	<i>Болдбаатар</i>
Өндөршил	Тунгалагмаа	<i>Тунгалагмаа</i>
Сайхан овоо	Тунгалагтуяа	<i>Тунгалагтуяа</i>
Хулд	Цэцэгсүрэн	<i>Цэцэгсүрэн</i>
Цагаандэлгэр	Саранчимэг	<i>М.С</i>
Эрдэнэдалай	Энхтайван	<i>Мян</i>

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, /2014 оны эхний хагас жилээр/
эвхмэл тархаасан жагсаалт

Сумын нэр	Төрийн сангийн төлөөлөгчийн нэр	Гарын үсэг
Сайнцагаан	Бархасмаа	<i>Бархасмаа</i>
Адаацаг	Баяржаргал	<i>Моран</i>
Баянжаргалан	Дуламханд	<i>Д.Д</i>
Говь-Угтаал	Уранбилэг	<i>Уранбилэг</i>
Гурвансайхан	Дагмид	<i>Дагмид</i>
Дэлгэрхангай	Батхуяг	<i>Батхуяг</i>
Дэлгэрцогт	Эрдэнэцэцэг	<i>Эрдэнэцэцэг</i>
Дэрэн	Цогтбаатар	<i>Цогтбаатар</i>
Луус	Ундрахбаяр	<i>Ундрахбаяр</i>
Өлзийт	Болдбаатар	<i>Болдбаатар</i>
Өндөршил	Тунгалагмаа	<i>Тунгалагмаа</i>
Сайхан овоо	Тунгалагтуяа	<i>Тунгалагтуяа</i>
Хулд	Цэцэгсүрэн	<i>Цэцэгсүрэн</i>
Цагаандэлгэр	Саранчимэг	<i>М.С</i>
Эрдэнэдалай	Энхтайван	<i>Мян</i>

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

2014.12.08

№	Тархаалтын хэлбэр	Тоо ширхэг	Давтамж	Бүгд
1	Танилцуулга / сар бүр /	12	12	144
2	Имайл хаягаар / сар бүр /	20	12	240
3	Танилцуулга / жилийн эцэс /	50	1	50
4	Имайл хаягаар / жилийн эцсийн танилцуулга /	50	1	50
5	Хэлтсийн ФК групп / гишүүн /	455	1	455
6	Хэлтсийн Page хуудас / LIKE /	363	1	363
7	Биечлэн ирж авсан хүн	70	1	70
8	“Дундговь амьдрал” сонин	10000	2	2000
8	Хэлтсийн вэб хуудас	57729	1	57729
Бүгд				61101

IV БҮЛЭГ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, ТӨСӨВТ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, АШИГЛАЛТ


14. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ (Ш14)

Статистикийн хэлтсийн ажлын тайланг Үндэсний статистикийн хорооноос баталсан журам, бүтээгдхүүн нийлүүлэлтийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг 14 хоног тутам ҮСХороо, аймгийн Засаг дарга удирдлагуудад танилцуулан хэлтсийн зөвлөгөөнөөр хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хэлтсийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний статистикийн хорооны даргаар батлуулан ажилласан ба нийтдээ хэрэгжүүлэх 33 ажил төлөвлөгдсөн ба аймгийн Засаг даргын орлогчоор улирал бүрд хийх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан биелэлтий нь тооцон ажиллаж байна.

Аймгийн засаг дараг болон статистикийн хэлтсийн даргын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ байгуулан биелэлтий нь тооцон ажиллаж байна. Мөн аймгийн засаг даргаар хэлтсийн жилийн төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. /

Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт хавсралтаар /



Хэлтсийн хүний нөөцийг бэхжүүлэх зорилгоор төрийн албаны салбар зөвлөлийн нөөцөд бүртгэлтэй байсан Т.Бямбасүрэн, төрийн албаны салбар зөвлөлын шалгалтанд тэнцсэн Б.Зүмбэрэл нарыг ҮСХороо, Авилгалтай тэмцэх газар холбогдох баримтыг хүргүүлэн зөвшөөрлыг авч томилоод байна. Хэлтсийн ахлах мэргэжилтэнээр тус хэлтэст 5 жил ажилласан Ж.Уянгыг ҮСХороотой зөвшилцөн томилоод байна.

Хэлтсийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах, мэдлэг мэргэжилээ дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллаж байна. Ажлын байрны дасгал хөтөлгөөний идэвхжүүлэх, 7 хоног бүр аймгийн байгаль орчны газартай хамтран 2 цаг спорт зааланд тоглох зэрэг ажлыг тогмол хийж хэвшээд байна.

Хэлтсийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 4 хүний оффис ширээ, MOHEL-ын үс шүүгч, дүрэмт хувцас, зурагийн цомог, 7 ширхэг сандал шинээр



авч, мэдээллийн самбар зэрэг ажлуудыг хийгээд байна.

Хэлтсийн хүний нөөцийн мэдээллийн санг хэлтсийн мэргэжилтэн Т.Бямбасүрэнгийн ажил үүргийн хуваарьт оруулан мэдээллийг сар бүр шинэчлэн ажиллаж байна.

15. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ӨГӨӨЖ (Ш15)

Мэдээ тайланд тавих хяналт, шалгалтын графикчилсан төлөвлөгөөг баталж, оны эхнээс мөрдүүлэн ажиллаж нэгж, байгууллага дахь Статистикийн тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилт, Статистикийн мэдээллийн үндэслэл, үнэн зөв, шуурхай байдал, статистикт хамрагдалтын байдлыг шалгав.

Графикийн дагуу бүх сумдад хэлтсийн мэргэжилтнүүд ажиллаж, ажлыг нь удирдамжийн дагуу шалган тусалж ажлын чиглэл, зааварчлага өгч, илэрсэн дутагдал зөрчлийг засуулах арга хэмжээ авч ажиллалаа. Мөн хэлтсийн мэргэжилтнүүдэд өөрсдийн хариуцсан салбараас шалгах санал ирүүлсэн 4 аж ахуй нэгжийг шалгаж заавар зөвлөгөө өгсөн.

16. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш16)

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэн, анхан шатны бүртгэлүүдийг заавар журмын дагуу хөтөлж, батлагдсан төсвийг зардлын зүйл ангид багтаан үр ашигтай захиран зарцуулж байна. Аймгийн аудитын байгууллагаар 2013 оны жилийн

эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулалт хийлгүүлж зөрчилгүй гэсэн дүгнэлт гарсан ба цаашид мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төсвөөс олгож буй аливаа урамшуулал, унаа хоолны хөнгөлөлтөөс хүн амын орлогын албан татварын 10 хувийг суутган тооцож, татварын хэлтсийн зохих дансанд төвлөрүүлэн ажиллав. Нягтлан бодох бүртгэлийн стандарт АСОЛОУС-програмд бүх санхүүгийн гүйлгээ, үндсэн хөрөнгө, цалингийн тооцоонуудыг оруулж хэвшсэн ба батлагдсан төсвийг зөв зохистой, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр авлага үүсгэхгүйгээр, арвилан хэмнэлтийн бодлогыг тууштай нэвтрүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн ажилтнуудад картаар эзэмшүүлж байгаа үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд нь байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Эхний хагас жилийн санхүүгийн тайлан балансыг 7 р сарын 10 ны дотор гаргахаар бэлтгэл ажлыг хийж байна

ДУНДГОВЬ АЙМГИЙН

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2014.12.10